



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/131/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын

менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Зөвлөмж.....	8
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	10

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.18 № 90
танай _____ -ны № _____ -т

Баян-уул сумын иргэдийн
Төлөөлөгчдийн хурлын нарийн
Бичгийн дарга Г.Түмэнжаргал танаа

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Уул сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Уул сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

011020112



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,269,890.00	1,269,890.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,269,890.00	1,269,890.00
354	Хангамжийн материал	1,269,890.00	1,269,890.00
35420	Аж ахуйн материал	1,269,890.00	1,269,890.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,649,693.94	4,881,904.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,649,693.94	4,881,904.26
392	Биет хөрөнгө	14,649,693.94	4,881,904.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,777,000.00	7,427,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,425,879.27)	(3,436,728.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,069,400.00	3,634,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,770,826.79)	(2,742,766.83)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	10,000,000.00	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,919,583.94	6,151,794.26
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,919,583.94	6,151,794.26
51	Засгийн газрын хувь оролцоо	15,919,583.94	6,151,794.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,672,780.43	12,672,780.43
51101	Өмч: - төрийн	12,672,780.43	12,672,780.43
512	Хуримтлагдсан үр дүн	2,894,796.76	(6,872,992.92)
51210	Өмнөх үеийн үр дүн	2,894,796.76	2,894,796.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	(9,767,789.68)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,006.75	352,006.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,919,583.94	6,151,794.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	104,347,400.00	308,521,202.03
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	104,347,400.00	308,521,202.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	6,848,800.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	6,848,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,000,000.00	241,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	241,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,347,400.00	60,672,402.03
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,347,400.00	60,672,402.03
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	103,470,190.06	308,288,991.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,470,190.06	308,288,991.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,219,410.06	63,353,491.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,573,000.00	51,054,866.00
210101	Үндсэн цалин	32,275,400.00	24,794,614.00
210102	Нэмэгдэл	-	11,757,325.00
210104	Урамшуулал	12,297,600.00	14,502,927.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,572,800.00	6,324,148.03
210201	Тэтгэврийн даатгал	3,788,400.00	4,324,155.03
210202	Тэтгэмжийн даатгал	446,000.00	506,540.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	356,700.00	404,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	97,694.00	76,353.00
210205	Эрүүл мэндийн даатгал	884,006.00	1,012,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,534,700.00	2,841,798.00
210401	Бичиг хэрэг	689,500.00	742,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,363,100.00	1,793,698.00
210404	Ном, хэвлэл	402,100.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000.00	270,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,471,000.00	186,000.00
210702	Дотоод албан томилолт	1,471,000.00	186,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	116,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	116,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,767,910.06	2,829,779.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,745,120.00	1,411,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,022,790.06	1,417,789.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,250,780.00	244,935,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,337,500.00	244,935,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,000,000.00	240,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	337,500.00	4,935,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,913,280.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,913,280.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	877,209.94	232,210.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	10,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	10,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(10,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	877,209.94	(9,767,789.68)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	104,347,400.00	308,521,202.03
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	104,347,400.00	308,521,202.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	6,848,800.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	6,848,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,000,000.00	241,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	241,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,347,400.00	60,672,402.03
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,347,400.00	60,672,402.03
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	104,347,400.00	308,521,202.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,347,400.00	308,521,202.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,096,620.00	63,585,702.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,573,000.00	51,054,866.00
210101	Үндсэн цалин	32,275,400.00	24,794,614.00
210102	Нэмэгдэл	-	11,757,325.00
210104	Урамшуулал	12,297,600.00	14,502,927.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,572,800.00	6,324,148.03
210201	Тэтгэврийн даатгал	3,788,400.00	4,324,155.03
210202	Тэтгэмжийн даатгал	446,000.00	506,540.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	356,700.00	404,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	97,694.00	76,353.00
210205	Эрүүл мэндийн даатгал	884,006.00	1,012,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,534,700.00	3,041,798.00
210401	Бичиг хэрэг	689,500.00	942,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,363,100.00	1,793,698.00
210404	Ном, хэвлэл	402,100.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000.00	270,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,900,000.00	1,450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,900,000.00	1,450,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,471,000.00	186,000.00
210702	Дотоод албан томилолт	1,471,000.00	186,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	116,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	116,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,745,120.00	1,411,990.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,745,120.00	1,411,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,250,780.00	244,935,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,337,500.00	244,935,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,000,000.00	240,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	337,500.00	4,935,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,913,280.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,913,280.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,672,780.43	352,006.75	2,894,796.76	15,919,583.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,672,780.43	352,006.75	2,894,796.76	15,919,583.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,672,780.43	352,006.75	2,894,796.76	15,919,583.94
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,672,780.43	352,006.75	2,894,796.76	15,919,583.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,672,780.43	352,006.75	2,894,796.76	15,919,583.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-9,767,789.68	-9,767,789.68
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,672,780.43	352,006.75	-6,872,992.92	6,151,794.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,549,000.0	67,521,202.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,549,000.0	67,521,202.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,613,500.0	62,585,702.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,055,000.0	51,054,866.0
210101	Үндсэн цалин	24,897,400.0	24,794,614.0
210102	Нэмэгдэл	11,654,600.0	11,757,325.0
210104	Урамшуулал	14,503,000.0	14,502,927.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,332,800.0	6,324,148.0
210201	Тэтгэврийн даатгал	4,345,400.0	4,324,155.0
210202	Тэтгэмжийн даатгал	500,400.0	506,540.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	420,100.0	404,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	78,600.0	76,353.0
210205	Эрүүл мэндийн даатгал	988,300.0	1,012,200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,291,800.0	2,291,798.0
210401	Бичиг хэрэг	642,100.0	642,100.0
210402	Тээвэр, шатахуун	1,343,700.0	1,343,698.0
210404	Ном, хэвлэл	-	36,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	306,000.0	270,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.0	1,200,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.0	1,200,000.0
2107	Томилолт, зочны зардал	186,000.0	186,000.0
210702	Дотоод албан томилолт	186,000.0	186,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х	116,900.0	116,900.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	116,900.0	116,900.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,431,000.0	1,411,990.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,431,000.0	1,411,990.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,935,500.0	4,935,500.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,935,500.0	4,935,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,935,500.0	4,935,500.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,549,000.0	67,521,202.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,549,000.0	67,521,202.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	67,549,000.0	67,521,202.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	241,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	241,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	750,000.00
210401	Бичиг хэрэг	300,000.00
210402	Тээвэр, шатахуун	450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	240,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	241,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	241,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	241,000,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг нарийн бичгийн дарга Г.Түмэнжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 06-наас 2021 оны 02 дугаар сарын 02-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй болно.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 103,470.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 2,069.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 318,288.9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 6,365.8 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,767.8 мянган төгрөгөөр буюу 66.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	1,269.9	1,269.9	-
Үндсэн хөрөнгө	14,649.7	4,881.9	(9,767.8)
Нийт хөрөнгө	15,919.6	6,151.8	(9,767.8)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,919.6	6,151.8	(9,767.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,919.6	6,151.8	(9,767.8)

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,881.9 мянган төгрөг болж 9,767.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилд 1,650.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан ч хөрөнгийн элэгдлийн зардал 1,417.8 мянган төгрөгөөр, 2005 онд хийгдсэн 10,000.0 мянган төгрөгийн дансны үнэтэй сумын танилцуулга номыг шийдвэрийн дагуу акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,151.8 мянган төгрөг болж 9,767.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Баян-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 214,818.7 мянган төгрөгөөр буюу 207.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь тайлант онд хэлмэгсдийн нөхөн олговор 240,000.0 мянган төгрөгийг сумын ИТХ-ын дансаар дамжуулан иргэдэд “төрөөс иргэдэд олгох тэтгэмж”-ийн зардлын ангиллын дагуу олгосонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 214,818.7 мянган төгрөгөөр буюу 207.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин урамшууллын зардал 14.4 хувь, төрөөс иргэдэд олгох тэтгэмжийн зардал 600 хувиар тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 77,514.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 77,514.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 9,965.2 мянган төгрөгөөр бууруулж 67,549.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан санхүүжүүлэхээр 67,549.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр нутгийн төсвөөс нийт 67,549.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 67,521.0 мянган төгрөгийг зарцуулж 28.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 67,521.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 28.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас /гэмт хэргээс урьдчилан сэргийлэх/ 1,000.0 мянган төгрөг, хэлмэгдсэн иргэдийн эхнэр нөхөр, үр хүүхдэд олгох нөхөн олговрын 240,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Тус санхүүжилтээс “бараа ажил үйлчилгээний бусад зардал”-д 1,000.0 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж 240,000.0 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж, 7 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 зарлагын 240.0 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр хамрагдаж, зөвлөмж өгөөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн болно.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

1. Хэлмэгдэгсдийн нөхөн олговор 120.0 сая төгрөгийн дансны бичилтийг хийхдээ 2 зардлын /213205-төрөөс иргэнд олгох тэтгэмж/ дансанд харьцуулан бичилт хийснийг санхүүгийн тайланд залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 33.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

1. "Бичиг хэргийн зардал"-аас 33.1 мянган төгрөгийг "Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал" зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баян-Уул сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/131/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баян-Уул сумын ИТХ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант оны 2 болон 3 дугаар саруудад төрөөс иргэдэд шилжүүлсэн нийт 240.0 сая төгрөгийн 4 гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.	240,000.0	Албан шаардлага	Дарга	Г.Түмэнжаргал
2	"Бичиг хэргийн зардал"-аас 33.1 мянган төгрөгийг "Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал" зарцуулсан байна.	33.1	Албан шаардлага	Дарга	Г.Түмэнжаргал
ДҮН		240,033.1			